



ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2013 оны Санхүүгийн тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

Т.Майцэцэг

Утас: 70273465

И-мэйл

Аудитор

О.Сосор

Утас: 70273204

И-мэйл

• Танилцуулга	1-7
• Санхүүгийн дотоод хяналт	7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Аудитын санал дүгнэлт	8

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

Төв аймгийн ГХБХБГазрын 2013 оны Санхүүгийн Тайланд ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид аймгийн ГХБХБГазрын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба ГХБХБГазрын Төсвийн Ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд ГХБХБГазрын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 оны батлагдсан төсөв 217646.1 мянган төгрөгөөр батлагдсан. 2013 онд улсын төсвөөс 217645.9 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, бусад төсөвт байгууллагуудаас орлого 18169.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 52283.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 1200.0 мянган төгрөг орсныг тайлан тэнцэлд бүрэн тусгасан байна.

-төсвийн харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 743.2 мянган төгрөгийг Сангийн яаманд буцаан төвлөрүүлсэн, орлогоос 50846.7 мянган төгрөгийг ГХГЗЗГазарт төвлөрүүлснийг төвлөрүүлэх шилжүүлгээр бүртгэсэн байна.

-Мөнгөн гүйлгээний тайланд НДхэлтсээс орж ирсэн листны мөнгө 2197.8 мянган төгрөгийг Засгийн газрын 2012 оны 205-р тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11.2 **төсвийн ерөнхий дансанд үлдэгдлийг төвлөрүүлэхэд орлого бууруулах гүйлгээ хийнэ** гэснийг зөрчсөн байна.

- Няравын ажил хавсран гүйцэтгэсний 20 хувийн цалинг бодож олгохдоо няравын цалингаас зохих хувиар бодож олгох

байтал, мэргэжилтний цалингаас бодож Ц.Бямбасүрэнд 55110 төгрөг, Ч.Наранд 72514 төгрөгийн цалин илүү олгосон байна. Барилга угсралт технологи, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрч өөрийн саналаар ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2013.12.02 ны өдрийн 42 тоот тушаалаар ажлаас чөлөөлсөн байна. Мөн 2013.12.02 ны өдөр түр тушаал гарган ажиллуулж зэрэг дэв, ТАХ-ын нэмэгдэл 245874 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн.

- Албан томилолтоор ажилласан мэргэжилтнүүд томилолтын урдчилгаа аваад тооцоо хийгээгүй, санхүүгийн баримтанд томилолтын хуудас байхгүй 4 ажилтантай холбоотой 240.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Мөн албан томилолтоор ажилласан мэргэжилтнүүдэд 105.5 мянган төгрөгийн томилолтын мөнгө илүү олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 39 тоот тушаалын 17-д **“албан томилолтоор ажилласан хүмүүс урдчилгаагаар авсан мөнгөний тооцоог ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор томилолтын үнэмлэх, байр, уналгын хөлс төлсөн баримтыг үндэслэн хийж дуусгана,”** гэсэн заалтыг зөрчсөн байна.

ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

Санхүүгийн тайлангийн аудитаар ажлын баримтанд үндэслэн 1968.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Нийт зөрчил нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2014 оны 2-р сарын 07-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Д.Бадамханд олон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын

дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор

О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.02.06

Танилцуулга

1. Бид аймгийн ГХБХБГазрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба аймгийн ГХБХБГазрын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд аймгийн ГХБХБГазрын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь аймгийн ГХБХБГазрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Аймгийн ГХБХБГазрын даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд ГХБХБГазрын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1 .Орлого,санхүүжилтийн талаар

Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна.

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 онд урсгал санхүүжилт 217646.1 мянган төгрөгөөр батлагдсан. 2013 онд улсын төсвөөс 217645.9 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, бусад төсөвт байгууллагуудаас орлого 18169.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 52283.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 1200.0 мянган төгрөг орсныг тайлан тэнцэлд бүрэн тусгасан байна.

Харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 743.2 мянган төгрөгийг Сангийн яаманд буцаан төвлөрүүлсэн, орлого 50846.7 мянган төгрөгийг ГХГЗЗГазарт төвлөрүүлснийг төвлөрүүлэх шилжүүлгээр бүртгэсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайланд НДхэлтсээс орж ирсэн листны мөнгө 2197.8 мянган төгрөгийг залруулан Засгийн газрын 2012 оны 205-р тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11.2 *төсвийн ерөнхий дансанд үлдэгдлийг төвлөрүүлэхэд орлого бууруулах гүйлгээ хийнэ* гэснийг зөрчсөн байна.

2. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 386858.8 мянган төгрөг, тайлант онд үндсэн хөрөнгө нь 85804.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас 5000.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 467662.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хөрөнгийг хүлээн авсан акт шийдвэрийг үндэслэн дараахь хөрөнгийг холбогдох дансад орлогдсон байна. ГХГЗЗГазраас 2013.10.07 ны өдөр Ландкрузер 76 маркийн 82491.7 мянган төгрөгийн дансны үнэтэй автомашин данснаас дансанд шилжиж ирснийг данс бүртгэлд тусгасан байна.

Төрийн өмчийн хорооны 2013.05.02 ны өдрийн 204 тоот тогтоолоор Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын хөдөө орон нутаг дахь салбарын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй автомашиныг худалдах шийдвэр гарч Леганз 62-95ТӨА улсын дугаартай 5000.0 мянган төгрөгийн үнэтэй автомашиныг 1300.0 мянган төгрөгөөр худалдах шийдвэр гарч дуудлага худалдаа зарлан худалдсан байна. Машины дуудлаг худалдааны үнэ 1340.0 мянган төгрөгийг 90019006 тоот дансанд 2013.08.21 ны өдөр тушаасан байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг ГХБХБГазрын даргын 2013.12.19 ны өдрийн 46 тоот тушаалаар томилж тооллогын комиссууд тооллогыг хийсэн байна. Программ хангамж 1950.0 мянган төгрөгөөр дансанд бүртгэлтэй.

Бараа үйлчилгээнээс зардлаас 3100.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн. Үндсэн хөрөнгийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу шулуун шугамын аргаар тооцсон байна.

Эд хөрөнгийн ашиглалтын картанд хөрөнгийн үнийг бичээгүй зөвхөн хөрөнгийн нэр, тоог бичиж бүртгэсэн байсан.

3. Бараа материал

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 28214.7 мянган төгрөг, орлого 9110.1 мянган төгрөг, зарлага 19933.8 мянган төгрөг гарч 17391.0 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтыг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудасанд зөвшөөрсөн, олгосон хүний гарын үсэггүй баримтын бүрдэл дутуу, нярав нэр төрлийн тайланг сар бүр гаргаагүй зөрчил илэрсэн.

Суудлын автомашины замын хуудсыг бичсэн боловч байгууллагын дарга батлаж гарын үсэг зураагүй, хариуцсан хэрэглэгчээр гарын үсэг бүрэн зуруулаагүй, замын хуудсанд стидометрийн заалт бичээгүй байгаа зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 7.5-д **“анхан шатны баримтанд түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”**, гэсэн заалтыг зөрчсөн байна. Авто машинд сэлбэг хэрэгслийг авахдаа техникийн комиссын дүгнэлт гаргуулалгүй сэлбэгийг худалдан авч зарцуулж байна. Орон тооны нярав байхгүй няравын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа ажилтан нь материалын тайланг нэр төрлөөр нь гаргаагүй байсан.

4.Цалингийн талаар

ГХБХБГазрын даргын 2013.01.10 ны өдрийн 05 тоот тушаалаар ажилтан албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон.

Цалингийн баримтыг шалгахад цалингийн хүснэгтэнд ажиллагсдаар гарын үсэг бүрэн зуруулаагүй зөрчил илэрсэн. Ажиллагсдад цалингийн урдчилгаа олгоод цалингаас суутгагүй 6 хүнтэй холбоотой 1550.0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй зөрчил илэрсэнд акт бичигдсэн.

Орон тооны нярав байхгүй тул 3-р сарын 01 нээс мэдээлэл технилогийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн, 2013 оны 10 сарын 19 ны өдрөөс эхлэн няравын ажлыг хавсран гүйцэтгэсэн байна. Няравын ажил хавсран гүйцэтгэсний 20 хувийн цалинг бодож олгохдоо няравын цалингаас зохих хувиар бодож олгох байтал, мэргэжилтний цалингаас бодож Ц.Бямбасүрэнд 55110 төгрөг, Ч.Наранд 72514 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Барилга угсралт технилоги, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрч өөрийн саналаар ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2013.12.02 ны өдрийн 42 тоот тушаалаар ажлаас чөлөөлсөн байна. Мөн 2013.12.02 ны өдөр түр тушаал гарган ажиллуулж зэрэг дэв, ТАХ-ын нэмэгдэл 245874 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн.

5.Бараа үйлчилгээний зардал

Албан томилолтоор ажилласан мэргэжилтнүүд томилолтын урдчилгаа аваад тооцоо хийгээгүй, санхүүгийн баримтанд томилолтын хуудас байхгүй 4 ажилтантай холбоотой 240.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Мөн албан томилолтоор ажилласан мэргэжилтнүүдэд 105.5 мянган төгрөгийн томилолтын мөнгө илүү олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 39 тоот тушаалын 17-д **“албан томилолтоор ажилласан хүмүүс урдчилгаагаар авсан мөнгөний тооцоог ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор томилолтын үнэмлэх, байр, уналгын хөлс төлсөн баримтыг үндэслэн хийж дуусгана,**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Түлш халаалт ,цэвэр бохир усны хэмнэгдсэн зардал 1760.4 мянган төгрөгийг СТСХэлтэст 2013.12.19 ны 07/842 тоотгоор хүсэлт гарган шатахуунд 1502.3 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардалд 258.1 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Унаа хоолны зардлаас материалын зардалд 254.1 мянган төгрөгийг төрийн санд хүсэлт гаргалгүй гүйлгэн зарцуулсан байна.

6.Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайланд НДхэлтсээс орж ирсэн листны мөнгө 2197.8 мянган төгрөгийг залруулан Засгийн газрын 2012 оны 205-р тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11.2 **төсвийн ерөнхий дансанд үлдэгдлийг төвлөрүүлэхэд орлого бууруулах гүйлгээ хийнэ** гэснийг зөрчсөн. Төрийн сангаар гүйлгээ хийсэн баримт бүрт төрийн сангийн тэмдэг дарж баталгаажсан байна.

7.Авлага ,өглөгийн талаар

Төв Чандмань ДЭХГ-т халаалт болон цэвэр,бохир усны үнэнд нэхэмжлэхээр 14111.4 мянган төгрөгийн шилжүүлсэн байна.Төв чандмань ДЭХГ-аас ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 14111.4 мянган төгрөг .Хоорондын тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Цахилгааны үнэнд 1250.4 мянган төгрөг нэхэмжлэхээр төлсөн. ХҮТ-өөс ирүүлсэн өр ,авлагын тооцоогоор 1250.4 мянган төгрөг байгаа нь төлсөн мөнгөий дүн тохирч байна.

НДХэлтэс, Татварын хэлтэстэй тооцоогүй тайланг гаргаж хянуулсан байна.

Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлаг үүсгэн бүртгэсэн. Харилцагч байгууллагуудаас НДХэлтэс,Төв Чандмань ДЭХГ, Мандухай цэцэн ХХК- тай тооцоо нийлж актыг үйлдсэн боловч тооцооны баримтын жагсаалт хийгээгүй байна. Тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтанд нэгтгэн гаргахгүй байгаа нь нийт төлсөн мөнгө болон бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжилсэн дүн тодорхой бус байна.

8. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 6.4-д заасныг үндэслэн “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батласан журмын дагуу байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтанг томилон ажиллуулах ёстой байтал дотоодын хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж хяналт шалгалт хийгээгүй байна

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5.Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6.Эдгээр асуудлуудыг ААГ болон аймгийн ГХБХБГазрын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7.Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар 82491.7 мянган төгрөгийн дансны үнэтэй автомашин данснаас дансанд шилжиж ирснийг засгийн газрын сангийн кт талаас дансны бичилт хийснийг залруулаагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт

- Зардлыг бүлгээс бүлэгт шилжүүлэхдээ Сангийн сайдын 2010 оны 48 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5.5-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах
- НББ-ийн тухай хуулийн 7.4-д “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.06